



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбоо, мэдээлийн технологийн газрын харьяа Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн “дуусаагүй үйлдвэрлэл” дансанд бүртгэлтэй, 17 нэрийн нийт 1,213,339,839.00 (нэг тэрбум хоёр зуун арван гурван сая гурван зуун гучин есөн мянга найман зуун гучин есөн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Харилцаа холбоо, мэдээлийн технологийн газрын харьяа Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн дарга Б.Болор-Эрдэнэ, “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ашиглах хугацааны элэгдэл хорогдол шимтгэлийг тооцон нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001287

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн
3.9 дугаар тогтоолын хавсралт



**"БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГИЙН ДУУСААГҮЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ДАНСАНД
БҮРТГЭЛТЭЙ "МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨХХК-Д БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
					(төгрөгөөр)	
Барилга байгууламж						
1	Техникийн байр 12х9м /Увс Зүүнхангай сум/	2019	ш	1	93,000,000.00	93,000,000.0
2	Техникийн байр 12х9м /Хөвсгөл Цэцэрлэг сум/	2019	ш	1	92,000,000.00	92,000,000.0
3	Техникийн байр 12х9м /Сэлэнгэ Хушаат сум/	2019	ш	1	91,000,000.00	91,000,000.0
4	Цамхаг/Төмөр 20м /Увс Зүүнхангай сум/	2019	ш	1	39,832,590.00	39,832,590.0
5	Цамхаг/Төмөр 20м /Хөвсгөл Цэцэрлэг сум/	2019	ш	1	39,762,553.00	39,762,553.0
6	Цамхаг/Төмөр 20м /Сэлэнгэ Хушаат сум/	2019	ш	1	37,853,026.00	37,853,026.0
7	Техникийн байр 12х9м /Хөвсгөл Рэнчинлхүмбэ сум/	2019	ш	1	129,661,855.00	129,661,855.0
8	Цамхаг/Төмөр 20м /Хөвсгөл Рэнчинлхүмбэ сум/	2019	ш	1	40,338,145.00	40,338,145.0
9	Техникийн байр 12х9м /Хэнтий Дадал сум/	2019	ш	1	101,034,512.00	101,034,512.0
10	Техникийн байр 12х9м /Хөвсгөл Батширээт сум/	2019	ш	1	101,532,613.00	101,532,613.0
11	Цамхаг/Төмөр 20м /Хэнтий Дадал сум/	2019	ш	1	38,643,728.00	38,643,728.0

12	Цамхаг/Төмөр 20м /Хэнтий Батширээт сум/	2019	ш	1	38,145,627.00	38,145,627.0
13	Цамхаг/Төмөр 20м /Увс Баруунтуруун сум/	2019	ш	1	30,295,255.00	30,295,255.0
14	Цамхаг/Төмөр 20м /Архангай Цахир сум/	2019	ш	1	30,421,437.00	30,421,437.0
15	Цамхаг/Төмөр 20м /Говь-Алтай Хөхморьт сум/	2019	ш	1	30,729,194.00	30,729,194.0
Дүн				15		934,250,535.0
Тоног төхөөрөмж						
16	G652D стандартын 12 шөрмөстэй шилэн кабель	2019	м	35370	7,676.45	271,516,019.0
17	ZXMP S200 SDH төхөөрөмж	2019	ш	1	7,573,285.00	7,573,285.0
ДҮН				35371		279,089,304.0
Нийт дүн				35386	1,213,339,839.00	
					Нэг тэрбум хоёр зуун арван гурван сая гурван зуун гучин есөн мянга найман зуун гучин ес	